

Хятадын коммунистууд марксизмын үзэл санааг төгс хүлээн авч ленинист маягийн нам байгуулахад туйлын бэрхшээлтэй байсан нь тэр үеийн Хятадын улс төрийн хүнд төвөгтэй нөхцөл байдал, хятадын коммунист намын ихэнх гишүүд Гоминданы үйл ажиллагаанд «татагдан идэвхтэй оролцож байсан болон Лениний нас нөгчсөний дараа ЗХУ-д намын доторхи фракцийн тэмцэл өрнөсөнтэй холбоотой юм. Маог 20 иод онд хувьсгалт үйл ажиллагаагаа ид өрнүүлж явахад нь марксизмын үзэл санааг судлах цаг завын бололцоо тун бага байжээ. Хүмүүсийг удирдах төрөлхийн авьяастан Мао ардчилсан төвлөрсөн удирдлагат ленинист намын хатуу дэгэнд баригдах хэцүү гэж үзэж байжээ. Тэр марксизмын үзэл санааны үндсэн зарчмыг хүлээн авч намын доторхи зарчмыг шийдвэрлэхэд ардчилсан төвлөрсөн систем хэрэгтэйг хүлээн зөвшөөрснийхээ дараа ч Хятад оронд коммунизмыг ялуулах асуудалд бүх анхаарлаа чиглүүлсэн хувьсгалч хэвээрээ үлдсэн юм. Тэрээр Сталины хүссэн ёсоор хятадын хувьсгалын эрх ашгийг ЗХУ болон дэлхийн коммунист хөдөлгөөний эрх ашигт нийцүүлэн захируулахын төлөө зүтгэхийг хүсээгүй билээ.

Мао 1918 онд Хунаний багшийн сургууль төгсөхөөсөө өмнө диалектик материализмын үндсийг аль хэдийнээ эзэмшсэн байсан гэж маогийн тухай магтаалд өгүүлдэг. Иймэрхүү хэтрүүлэг магтаалд харин Мао өөрөө буруугүй бололтой. 1936 онд Сноутай хийсэн ярилцлагадаа Мао: «Тэр үед би идеалист байсан... Миний толгойд либерализм, ардчилсан реформист болон үл гүйцэлдэх социализмын үзэл хоорондоо холилдон байсан юм. Би XIX зууны ардчилсан, үл гүйцэлдэх үзэл болон хуучин маягийн либерал үзлийн тухай бүдэг бадаг ойлголттой, харин дайны эсрэг, империализмын эсрэг үзлийг хатуу баримталж байсан» гэжээ.

Мао, өөрийн багшийн сургуулийн багш, хожим хадам аав нь болсон Ян Чанжигийн нөлөөгөөр идеалист үзлийг нэлээд хэмжээгээр тусгаж авчээ. Английн философич Ч. Гриний сургаалыг баримтлагч Ян ахлах ангийн оюутнуудад неокантын үзэл нэвт шингэсэн Фридрих Паулсены «Этикийн систем» номыг сурах бичиг болгон ашиглаж байжээ. Энэхүү номыг Бээжингийн үндэсний их сургуулийн ректор анархист үзэлтэн Цай Юэн Пэй Хятад хэлнээ хөрвүүлсэн байна. Миний сэтгэхүйн чадал» хэмээх Маогийн бичсэн бэсрэг өгүүлэл Яны зүгээс өндөр үнэлэлт авч байсан нь Мао этикийн идеализмын үзлийг хэрхэн шингээж авсан хийгээд марксист үзэл санааг эзэмших яагаа ч үгүй байсныг харуулсан юм.

Мао тус зохиолдоо: «Миний бодоход хийсвэр ойлголт бол бодит, байдал, хязгаарлагдмал ба хязгаарлагдмал бус байдал, цаг зуурын юм бол цаг зуурын бус, би бол орчлонт ертөнц, амьдрал бол үхэл, үхэл бол амьдрал, одоо цаг өнгөрсөн цаг буюу ирээдүй цаг, өнгөрсөн ирээдүй цаг бол одоо цаг, бага бол их, намхан бол өндөр, ядуу бол баян, бүдүүн бол нарийн, олон юмс бол ганц юм, өөрчлөгдөж буй зүйл

*Жон Рые-гийн зохиосон «Мао Зэдун 1927—1935 онд» хэмээх Стенфордын их сургуулиас 1966 онд хэвлэн гаргасан номноос авав.

бол мөнх» гэж бичжээ. Диалектик үзэл санаагаар нэвт шингэсэн энэ хүү бэсрэг өгүүлэл нь Хятадын философийн хийгээд Гегель, Қантын. онолын нэлээд нөлөөн дор бичигдсэн бөгөөд харин тус зохиолд нийгмийн анги, давхраа, улс төрийн системийн тухай марксист үзэл огтхон ч тусгагдаагүй байна.

Тухайн үед Мао хэдий марксизм, ленинизмын үзлийг баримтлагч байгаагүй ч эцсийн эцэст тухайн улс төрийн дэглэмийн эсрэг залуу сэхээтний халуун омгоор эсэргүүцэн тэмцсэн юм. Эцэг нь түүнийг хуучин ёс заншлаар гэрлүүлэхэд эцгийнхээ үгнээс зөрж авааль гэргийн хамт амьдрахаас эрс татгалзан гэрээсээ явж, зэргэлдээх мужийн тэр үеийн дэвшилтэт сургалттай сургуульд орж суралцжээ. Дунд сургуульд байх үедээ Мао эхийнхээ сүсэглэдэг бурхны шашныг мөн эсэргүүцэн хүлээж аваагүй бөгөөд манжийн төр мөхөхөөс нэг жилийн өмнө манжийн төрд дагаар орсоны илэрхийлэл болж байсан гээгээ тайрч хаяад улмаар 1911 онд ардчилсан хувьсгал гарсаны дараа хувьсгалт армид элсэн оржээ. Мао 1915 онд Чэнь дусю-гийн эрхлэн гаргасан «Залуус» сэтгүүлийн анхны дугаарт нийтлэгдсэн уриаг хамгийн түрүүнд хүлээж авсан хүний нэг. Тэрээр явцгүй уламжлалт сургалтыг эсэргүүцэж, орчин үеийн боловсролыг эрхэмлэх болжээ. Мао анхны өгүүллээ хятадын уламжлалт аргаар бичсэн бөгөөд тэр нь «Залуус» сэтгүүлийн 1917 оны 4-р сарын 1-ны дугаарт хэвлэгдсэн байна. Уг өгүүлэлд Мао Кунзын сургууль дахь ахмад дээдсээ хүндэлддэг ёс чухамдаа улс үндсээ гэсэн үзлийг бүрэлдүүлэхэд болон үндэсний хүчирхэг арми байгуулахад саад болж байгааг шүүмжилжээ.

Мао Синьхайн хувьсгал гарсаны дараа Чанша дахь оюутны хөдөлгөөний нэг удирдагч болжээ. Тэр даруу төлөв зантай, ангийнхнаасаа насаар нэлээд ахимаг, барагтай хүнд мөчөөгөө өгөхгүй, бусдыг ч өмгөөлөх чадвартай байсан бөгөөд зарим багш нар оюутнуудад хэрцгий шударга бусаар хандаж байсныг илэн далангүй шүүмжилж байжээ. Ангийн нэгэн нөхөртөө тусалж гэрлэлтийг нь цуцлуулах тухай сургуулийн захиргаатай ярьж өгч байжээ. 1915 онд сургуулийн захиргааныхан сургуулийн өмч хөрөнгөд зохисгүй хандаж буйг эсэргүүцэн Мао оюутнуудыг бослогод уриалж хөөгдөхийн даваан дээр түүнийг 4 багш өмгөөлсний ачаар гайгүй өнгөрчээ. 1916 онд ерөнхийлөгч Юань Шикай шинээр хаант төр тогтоох гэж байгааг Чанша дахь оюутнууд эсэргүүцэх үеэр тэрээр Юань Шикайг элэглэн шүүмжилсэн Лян Ци Чаогийн памфлетыг ил тарааж явжээ. Юань Шикай нас барсаны дараа удалгүй Хятад улс Хойд, Өмнөд хэсэгт хуваагдан хоорондоо дайтаж Чаншад дайны ажиллагаа эхлэхэд Мао сургуулийн байраа хамгаалах ажлыг зохион явуулжээ. Хойд Хятадын армийн цэргүүд сургуулийн байрыг эзлэн авахад Мао бусад оюутны хамт цагдаагийн газраас винтов буу авч шөнө дунд сургуулийг бүслэн гал нээхэд эзлэгсэд өмнөд армийн цэргүүд хэмээн эндүүрч сургуулийн байрыг орхин оджээ. Мао багшийн сургуульд орсоноос хойших хугацаанд Хунаньд нэг л жил дайн байлдаангүй амгалан тайван байв. Цэргүүд Чаншагийн сургуулийг байн байн дээрэмдэж байх тэр үед Мао оюутнуудын дотроос эр зоригоороо шалгарч тэдний удирдагч нь болжээ. Багш нарын дунд ч нэр хүнд олж авсан байна.

Тэр 1915—1918 онуудад Чаншагийн оюутны нийгэмлэгт ажиллаж улс төрийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж байсан нийслэлийн оюутнуудтай холбоо тогтоон 1915—1917 онд уг нийгэмлэгийн нарийн бичгийн даргаар ажиллаж, багшийн сургууль төгсөх жилдээ даргаар нь сонгогджээ. Үйл ажиллагаагаа цаашид өргөжүүлэх зорилгоор нийгэм-

лэгийн гишүүд дотроос улс төрийн ажилд дур сонирхолтой оюутнуудыг эрэлхийлэн хайхын хамтаар 1917 оны хавар орчин үеийн мэдлэг, эх оронч үйл ажиллагаа сонирхогчдын бүлэг байгуулахыг мэрийжээ. Маогийн тэмдэглэлд дурьдсанаар 3—4 оюутан түүнд элсэхээр саналаа өгчээ. Тэдгээр оюутнуудын нэг нь ХКН-ын ирээдүйн удирдагчийн нэг Лу Чаньлун байсан бөгөөд тэр 1931 онд баруунтны хэргээр хэлмэгдсэн ажээ. Нөгөө хоёр нь хэт реакционерууд байсан бөгөөд Мао тэдний нэрийг дурьдаагүй байна. Хагас дутуу сонирхож байсан нь 1928-1930 оны хооронд ХКН-ын дарга байсан Ли Лисань бөгөөд гэхдээ тэр удалгүй бүлгэмээс гарсан байна. Дараа жилүүдэд Мао «Син мин сюэ хуй» нийгэмлэгийг (шинэ ардын суралцах нийгэмлэг) амжилттай байгуулжээ. «Хятадын залуу үеийг бэхжүүлэх замаар хятадын нийгмийг хүчирхэг болгох» лоозон дэвшүүлэн үйл ажиллагаагаа явуулсан энэ нийгэмлэгийн 70—80 гишүүний нэлээд нь ХКН дотор нэр хүндтэй болж, цаашдаа маоист бүлэглэлийн амин сүнсийг бүрдүүлжээ. Нийгэмлэгийн бүрэлдэхүүнд байсан Цай Хуо Шэн, Лу Чань Лунь, Цян Циню, Цзя Ши, Цяо Чэнь, Е Ли Юнь, Ку Лян болон Хэ Шу Хэн нар 1935 оноос өмнө эрсдэж эсвэл ХКН-аас хөөгдсөн бөгөөд харин Лю Шаоци, Чжэн Пиши, Ли Фучунь, Ван Жо фэй, Тэн Тайюань, Ли Вэйхань, Ли Лисань, Сяо Цингуан, Цай Чан, Сяо Чучан нар 1945 онд бүгдээрээ ХКН-ын дээд удирдлагад багтаж оржээ. ХКН-ын нэрт зүтгэлтэн Цю Тэли тус нийгэмлэгийн удирдагчдын нэг байсны гадна Маогийн ирээдүйн хадам Ян Чанчи нийгэмлэгийн ивээн тэтгэгчдийн нэг байжээ.

1918 он гэхэд иймэрхүү оюутны нийгэмлэгүүд Хятадад дараа дараагаараа байгуулагдаж, Чжоу Эньлай, Дэн Инчао нарын байгуулсан Тяньцзиний «Сэхээрэл» нийгэмлэг, Юн Тайин, Линь Бяо, Чань Као нарын Уханьд байгуулсан «Энх амгалан нийгэмлэг» тэдгээрийн дотор хамгийн нэрд гарсан нь байв. Эдгээр нийгэмлэгүүд нь Оросын хувьсгал буюу марксизмын нөлөөн дор байгуулагдаагүй бөгөөд гол зорилго нь дэлхийн нэгдүгээр дайны үед Хятад руу түрэмгийлсэн Японы милитаризм, түүнчлэн Хятадын үндэсний эрх ашгийг империалистуудад худалдаж байсан цэргийн эрхэтнүүдийг эсэргүүцэх, ирээдүйд шинэ хүчирхэг Хятад улс байгуулахад чиглэгдэж байжээ. Нийгэмлэгүүдийн гишүүд Хятадын дотоод үйл амьдралд гол анхаарлаа чиглүүлж цагийн бэрхэд өөрсдийгөө огоорон явж байсан бөгөөд алс холын Петроград, Москвад болж буй үйл явдлаас хол хөндий байжээ.

Мао «Син мин сюэхуй» нийгэмлэгээ байгуулсныхаа дараа удалгүй багшийн сургуулиа дүүргээд цаашид боловсролоо дээшлүүлэх арга зам хайж байжээ. Яг энэ үеэр Гоминданийн анархист үзлийг дэмждэг зарим эрх баригчид Франц дахь холбоо сүлбээгээ ашиглаж Европт явж боловсрол олох мөнгөний бололцоогүй залуучуудыг үйлдвэрт ажиллуулж цаг заваар нь суралцуулах хөдөлмөр сургалтыг хослуулсан программыг хэрэгжүүлж эхэлжээ. Цай Хуошэнь Бээжин руу явж тэрхүү байгууллагыг олоод «Син мин сюэхуй» нийгэмлэгийн гишүүдэд Бээжинд хүрэлцэн ирж франц хэл сурч болох тухай мэдээ хүргэжээ. Уг нийгэмлэгээс олон хүн суралцахаар явсаны дотор Мао ч мөн оржээ. Мао франц хэл эзэмшиж хилийн чанадад суралцахаар яваагүй боловч гол нь Бээжинд байсан хувьсгалчидтай танилцаж холбоо тогтоож авчээ. Мао Бээжингийн үндэсний их сургуулийн номын сангийн эрхлэгч байсан ХКН-ыг үндэслэгч Ли Дажао-тай танилцсан нь түүний хувьд чухал ач холбогдолтой үйл явдал болжээ. Ли Дажао Маод их сургуулийн номын санд ажил олж өгчээ. Мао их сургуулийн сэтгүүлчдийн болон философийн ангийн оюутнуудын нийгэмлэгт элсэн орж ХКН-ыг үндэс-

лэгчдийн нэг Чан Готай-тай танилцжээ. Мао мөн 1926 онд Чжан Золиний тушаалаар цаазлагдсан сэтгүүлч Шао Пяопин болон 1919 онд Бүх Хятадын оюутны холбооны дарга байсан Дуань Шипэнтэй тус тус танилцжээ. Мао тухайн үед нэр алдар бүхий байсан Чэнь Дусю, Ху Ши нартай танилцсан боловч тэд өмнө зүгийн болхи хэллэгтэй бүдүүн баараг ядуу оюутанг төдийлөн ойшоож үзээгүй байна. Бээжинд Маотай хамгийн ойр дотны харилцаатай байсан хүмүүс бол нэг байр хөлслөн амьдарч байсан анархист үзэлтнүүд Чан Гунчи, Сюн Гуанчу, Цяо Юй, түүнчлэн Маогийн үзэл санаанд хамгийн их нөлөө үзүүлсэн оюутан Чу Сюнпэй нар юм. Тэд олон түмнийг хамарсан аливаа үйл ажиллагаа, нийтийн сургалтын системийг эрхэмлэн, хувьсгалын ач холбогдлыг хүртэл хүлээн зөвшөөрдөг хэрнээ анархистуудын нэгэн адил засаг төр, хэргэм тушаал, эд баялаг, хөрөнгө мөнгийг эсэргүүцэн эдгээрийг хулгай дээрэм, урван тэрслэх зэрэг бүх бузар булай юмны эх үүсвэр хэмээн үздэг байжээ. Тэдгээрийн нэг нь ч цаашдаа коммунист үзлийг хүлээж аваагүй байна. Мао эдгээр оюутнуудын тусламжтайгаар Кропоткин, Бакунин, Толстой нарын зохиолтой танилцсаны дүнд радикал үзлийг илүү танин мэдэж нийгэм дэх харш үзэгдэл, улс төрийн шударга бус бурангуй ёсны үндэс, мөн чанарыг шаргуу танин мэдэхийг мэрийх болжээ. Мао Бээжинд 7 сар болоод 1919 оны 2 сард нутагтаа буцах замдаа Шанхайгаар дайрч хөдөлмөр сургалтыг хослох программын дагуу франц хэл сурч байсан дотны нөхөдтэйгээ уулзжээ.

Тэр Хунаньд буцаж ирсэнийхээ дараа «Сян голын тойм» хэмээх оюутны сэтгүүл гаргасан боловч удалгүй түүнийгээ хааж «Шинэ Хунань» хэмээх сэтгүүл гаргаж эхэлсэн байна.

Энэ үед оюутнууд Хунаний засаг дарга, Японы талын Аньхой бүлгийн гишүүн Чан Циняог-ийн эсрэг ухуулга хийж байсан бөгөөд 12-р сард Мао оюутан багш нарын энэ тэмцлийг дэмжиж туслалцаа үзүүлжээ. Гэвч оюутны бослого дарагдаж, Маогийн сэтгүүл хаагдаж, Мао өөрөө Бээжин руу зугтахад хүрчээ.

Маогийн Хунаньд эрхлэж байсан сэтгүүлийн нийтлэлүүдийн үзэл санаа нь милитаризм, империализмын эсрэг тэрчлэн гадаадынхны эсрэг чиглэгдсэн байсан бөгөөд марксизмын үзэл санааг тусгаагүй байлаа. Мао марксизмын үзэл санааг Бээжинд дахин эргэж ирсэнийхээ дараа хүлээж авсан юм. Хоёр дахь удаагаа нийслэлд байх хугацаанд нь марксизмын байр суурийг баримтлагч Ли Дажао-гийн үзэл санаа түүнд нөлөөлжээ. Улмаар Мао бие даан марксист үзлийг тууштай судалж, өөрийгөө марксист гэж нэрлэх болсон нь чухам энэ үедээ Марксын «Коммунист тунхаг», Каутскийн «Ангийн тэмцэл», Киркуппын «Социализмын түүх» зэргийг уншжээ. Гэвч түүний марксист үзэл Лениний марксист үзлээс тэс ондоо байсан бөгөөд лениний зохиолуудтай ч тэр үедээ танилцаагүй байна. Тэр ардчилсан төвлөрсөн удирдлага болон пролетариатын диктатурын үе дэх намын ролийн тухай Лениний онолыг огт мэдэхгүй явжээ.

Мао Бээжинд анхны марксист бүлгэмүүдийн нэгэнд элсэн орсон боловч тухайн үед Чан Чиногаас Хунань мужаа хэрхэн нөлөөлөх тухай бодол түүнийг эзэмдэж байжээ. 1920 онд хойд милитарист бүлгүүдийн нэг Чжилигийн цэргийн бүлэглэл засгийн эрхэнд гарсанаар энэхүү асуудал шийдвэрлэгджээ. Чан Хунаниас зугатахад Мао гэртээ эргэж иржээ. Чангийн орыг Сунь Ятсены нөхөр Тан Энкай авсан бөгөөд тэр 1912 онд Хунаний анхны ардчилсан засаг дарга байжээ. Маог буцаж ирэхэд Тан жилийн өмнө Оюутнуудын бослогын үеэр алдагдсан боловсролын системийг сэргээж байв. Багшийн сургуулийн захирлаар томи-

логдсон багш и Пэйчи гэгч шинээр анги нээж Маог хятадын уран зохиолын багш, бага ангийн захирлаар ажиллахыг санал болгожээ. Мао энэ ажлыг 1920 оноос 1922 оны хичээлийн жилийг дуустал хийжээ. Мао Бээжин, Шанхайгаас 1920 онд Чаншад буцаж ирсэний дараа коммунист ном зохиолын орчуулгыг авч ирж түүнийгээ энэхүү зорилгоор байгуулсан соёлын дэлгүүрээр дамжуулан шаргуу тарааж эхэлжээ.

Маогийн номын дэлгүүр Ухань дахь Юан Тайины дэлгүүртэй тогтмол харилцаатай байсан ажээ.

1920 оны 11-р сард Мао залуу социалистуудын корпусын дүрмийг хүлээн авч Хунаньд тус байгууллагын анхны салбарыг байгуулжээ. Мао Цзедун «Син мин сюэ хуй»-ийн ажлаар Чаншад буцаж ирсэн Хо Шухэний хамт залуучуудын корпуст радикал үзэлтэй залуучуудыг биечлэн сонгон авч байв. Яг энэ үеэр Франц дахь тус нийгэмлэгийн хятад гишүүд мөн залуучуудын корпус байгуулсан ажээ. Үүнээс тун удалгүй ХКН-ын Хунань дахь анхны үүр байгуулагдсан бөгөөд түүний бүрэл дэхүүнд Маогийн итгэлийг хүлээсэн залуучуудын корпусын гишүүд орж байв. 1921 оны 6-р сард Хунаньд залуучуудын корпус болон ХКН-ын анхны үүр байгуулагдсаны дараа Мао, Хо Шухэн нар ХКН-ын анхны их хуралд оролцохоор Шанхай руу явжээ. Тэр үеэр Мао ХКН-ыг үндэслэгчийн нэг болов.

Хэдийгээр Мао тэр үед өөрийгөө марксист гэж байсан боловч Лениний гол зохиолуудын нэгийг нь ч уншаагүй байв. Тэр гадаад хэл мэдэхгүйн улмаас марксизм, коммунизмын тухай мэдлэгийг хятад орчуулгаар буюу хувийн харьцаанаас олж авч байв. Мао онолын хувьд ядмагхан байсан бөгөөд намын анхны их хурлаас боловсруулсан онолын сэдвийг судлаа ч үгүй ажээ. ХКН-ын даргаар сонгогдсон Чэнь Дусю түүнийг зөвхөн Хунаний хэмжээн дэх орон нутгийн шинжтэй үндэстний үзэлтэн гэжээ. Хунань дахь ХКН-ын үүр, залуучуудын корпуст Маогийн элсүүлэн авсан гишүүд нь гол төлөв түүний оюутан нөхөд, шавь, багш нар нь, дотны нөхөд буюу гэр бүлийнх нь байжээ. Тэр Хунаний ажилчин ангитай бараг холбоогүй байжээ. Мао хэдий тариачин гаралтай ч тариачид болон тосгоны амьдралыг дорд үздэг байжээ. Хэдий тийм боловч тэд маоист бүлгийн цөм нь болж нэгэн өдөр Хятад улсын удирдлаганд гарч чадсан юм. Хунаний фракцийн тодорхой зарим гишүүд хожим нь ХКН-ын нэрт удирдагчийн дүрээр Франц, Москва, Бээжин, Шанхай, Кантонд намыг төлөөлж байв. Дараачийн 5 жилд тэд орон нутгийн шинжтэй ХКН-ын бүлэглэл байгуулсан бөгөөд 1926 оноос хойш байр сууриа батжуулж эхэлсэн юм.

Англи хэлнээс орчуулсан Н. АРИУНГУА